

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТОЛООЛОН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр

№ 26/38

Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.23 дахь заалтууд болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тус эрэлтийг хангах, эх үүсвэрийн удирдлагын үр ашигт байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Жэй Эм Си Траст ББСБ” ХХК-аас энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөлийн хүрээнд зээл авахаар шийдвэрлэсүгэй.
2. “Жэй Эм Си Траст ББСБ” ХХК-тай энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. “Жэй Эм Си Траст ББСБ” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

